



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар A/95

ӨВТ

Г Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг
тооцох ажлын хэсэг байгуулах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт, Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам”-ын 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 4 дүгээр багийн нутаг Урд Агуйтын “Хуштай зураа” газарт 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр гарсан ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)

Гишүүд: Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

А.Мягмардагва (Ойн инженер)


Г.Пүрэвтогтох (Багийн Засаг дарга)

Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)

2. Ойн модны шаталтын зэрэглэл, түймрээс учирсан хохирлыг тогтоож, акт үйлдэн холбогдох газарт материалыг хүргүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч (Н.Орхонтуул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН



622201194

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/